ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/91 Арвайхээр сум

Хагас жилийн малын түүвэр судалгааг зохион байгуулах хяналтын тооллого явуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.1.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.в дэх хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хагас жилийн малын түүвэр судалгааг зохион байгуулах хяналтын тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Эрдэнэсүрэн (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга: Л.Доржханд (төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд: Г.Энх-Оюун (мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ж.Ганзориг (Санхүү албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Г.Золбаяр (бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ц.Эрдэнэжаргал (хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Хяналтын тооллогын тогтоосон хугацаанд заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ц.Эрдэнэсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б. ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx
622411224